

БАТЛАВ
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН, ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ДАВААЦЭРЭН

ATA12931 6594204 9024070548

**“ВЕНЕЦИЙН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ОЛОН УЛСЫН 61 ДЭХ УДААГИЙН
БИЕННАЛЬ”-Д ОРОЛЦОХ КУРАТОР, УРАН БҮТЭЭЛЧДИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ**

2025 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэг.Үндэслэл

Соёлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Олон Улсын тэргүүлэх зэрэглэлийн наадамд оролцох тухай” 73 дугаар тогтоол, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/337 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

Хоёр.Зорилго

Бүгд Найрамдах Итали Улсын Венец хотноо 2026 онд зохион байгуулагдах “Венецийн дүрслэх урлагийн олон улсын 61 дэх удаагийн Биенналь”-д Монгол Улсыг төлөөлөн оролцох уран бүтээлийн багийг сонгон шалгаруулахад оршино.

Гурав.Уран бүтээлийн багт тавигдах нийтлэг шаардлага

3.1.Уран бүтээлийн багт дараах нийтлэг шаардлагыг тавина. Үүнд:

3.1.1.олон улсын түвшинд өрсөлдөхүйц шинэлэг үзэл санаа, арга барил бүхий төслийн санааг дэвшүүлсэн байх;

3.1.2.оролцох бүтээлийн төслийг мэргэжлийн түвшинд боловсруулсан байх;

3.1.3.бүтээл нь оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй байх;

3.1.4.үзэсгэлэн дэглэлт, каталог баримтат кино хийх ажлыг чиглүүлэн ажиллах чадвартай, олон улсын түвшинд өрсөлдөхүйц туршлагатай байх;

3.1.5.Монгол Улсын үзэсгэлэнг зохион байгуулахдаа Венецийн биенналийн үндсэн үзэл баримтлал, зорилгод нийцүүлэн, аливаа ашиг сонирхлын зөрчилгүй, урлагийн мөн чанарыг дээдлэн, олон улсын туршлагатай сонгон шалгаруулах баг, байгууллага, кураторуудтай хамтран ажиллах.

3.2.Уран бүтээлийн багийн бүрэлдэхүүн ба эрх, үүрэг

3.2.1.уран бүтээлийн багт куратор, уран бүтээлч нар оролцох;

3.2.2.уран бүтээлийн баг нь өөрсдийн дэвшүүлсэн санаа, утга агуулга, арга барилын дагуу Венецийн дүрслэх урлагийн биеннальд оролцох Монголын павильоны үзэсгэлэнг зохион байгуулагчийн хамт дэглэн олон нийтэд үзүүлэхэд бэлдэх;

3.2.3.уран бүтээлийн баг нь үзэсгэлэн дэглэлтийн баг, хэвлэлийн дизайнер, редактор, зураглаач, кино найруулагчийг чиглүүлэх;

3.2.4.уран бүтээлч болон куратор нь үзэсгэлэнгийн павильоны сонголтод санал өгөх, сонголтоос татгалзах;

3.2.5.уран бүтээлийн баг нь үзэсгэлэнгийн агуулга болон хэвлэлийн мэдээ бэлдэж, үзэсгэлэнг сурталчлах тал дээр олон улс болон дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах.

Дөрөв.Уран бүтээлийн багт тавигдах тусгай шаардлага

4.1.Куратор нь дараах тусгай шаардлагыг хангасан байна:

4.1.1.дотоод куратор - контемпорари урлаг судлал, куратораар 5-аас доошгүй жил ажиллаж үзэсгэлэн, дүрслэх урлагийн арга хэмжээг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулсан туршлагатай байх;

4.1.2.гадаад куратор - олон улсын хэмжээний үзэсгэлэн, төсөл хөтөлбөрт 5-аас доошгүй жил ажиллаж байсан туршлагатай, уран бүтээлчийн үзэл санааг олон улсын түвшинд илэрхийлэх чадвартай, гадаад харилцаа холбоо сайтай байх;

4.1.3.санал болгож буй үзэсгэлэн нь Венецийн дүрслэх урлагийн биенналийн утга агуулгатай нийцсэн, бүтээлийн үзэл санаа, онцлог, илэрхийллийн хэллэг нь шинэлэг, давтагдашгүй, дэлхийн дүрслэх урлагт өөрийн гэсэн байр суурийг эзлэхүйц байх.

4.2.Уран бүтээлч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна:

4.2.1.Венецийн биенналийн үзэл санаа, тухайн жилийн үзэсгэлэнгийн утга агуулгад нийцсэн, онцгой, шинэлэг бүтээл туурвисан, эсхүл газар дээр нь туурвих санааг боловсруулсан байх;

4.2.2.Монгол Улсыг төлөөлөн оролцох уран бүтээлч нь өөрийн чиг хандлага, үзэл баримтлалтай, контемпорари урлагаар 5 болон түүнээс дээш жил бүтээлээ туурвиж байгаа, Монгол Улсаа төлөөлж чадахуйц шилдэг уран бүтээлч байх;

4.2.3.бие даасан үзэсгэлэн 5 ба түүнээс дээш удаа гаргаж, гадаад, дотоодын чансаатай үзэсгэлэнгүүдэд оролцсон байх.

Тав.Сонгон шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл

5.1.Сонгон шалгаруулалтын баримт бичиг дараах бүрдэлтэй байна:

5.1.1.төслийн танилцуулга (concept note, 3 хүртэл хуудсанд багтаах);

5.1.2.куратор болон уран бүтээлчийн portfolio (зураг, тайлбарын хамт);

5.1.3.куратор болон уран бүтээлчийн товч намтар (CV);

5.1.4.холбоо барих утас, хаяг.

Зургаа.Сонгон шалгаруулалт

6.1.Сонгон шалгаруулалтыг дараах 2 үе шаттай зохион байгуулна:

6.1.1.нэгдүгээр шатанд сонгон шалгаруулалтад ирүүлсэн уран бүтээлийн багийн баримт бичгийг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд томилсон 3 гишүүнтэй сонгон шалгаруулах баг хянан үзээд нэг багийг шалгаруулан ажлын хэсэгт танилцуулна.

6.1.2.хоёрдугаар шатанд ажлын хэсэг сонгон шалгаруулах багийн сонголтыг энэхүү удирдамжид заасан зарчимд тулгуурлан батлахгүй байх эрхтэй. Энэ тохиолдолд сонгон шалгаруулах багийн сонгосон 2 дахь багийн баримт бичгийг хэлэлцүүлж, ажлын 5 хоногт багтаан сонгон шалгаруулан, санал дүгнэлтийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад хүргүүлнэ.

6.2.Сонгон шалгаруулалтын материалыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 10:30 цаг хүртэл gereltsetseg@mocsty.gov.mn цахим хаягаар болон баримт бичгийг цаасаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 103 тоотод хүлээн авна.

Долоо.Бусад

7.1.Хугацаа хоцорсон, бүрдэл дутуу баримт бичиг хүлээн авахгүй.

Жич: Албан ёсны мэдээлэлтэй La Biennale di Venezia сайтаас танилцаж, сонгон шалгаруулалттай холбоотой нэмэлт мэдээллийг 51-265636, дугаарын утаснаас авна уу.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ